



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/396

Булган сум

Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 12 дугаар хэсгийн 12.13 дахь хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам”, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаалаар батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлага”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох цэгийн нэрийг хавсралтаар баталсугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-т заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга, Татварын газар (Д.Лхагвасүрэн), Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга)-д тус тус даалгасугай.

3.Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Д.Алтаншагай), сумын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 29-ны өдрийн
А/396 дугаар захирамжийн хавсралт



“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭРС

д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Хангал сум 2 дугаар баг Гүндэгийн хошуу	“Буян тэгш дүүрэн” ХХК	А.Оюу-Эрдэнэ	Амралтын газрын дэргэдэх ресторан	“Хангал ресорт”
	Нийт-7				

--о00о--